



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

“Монгол тэрбумтан” хадгаламж,  
зээлийн хоршооны тусгай зөвшөөрлийг  
сэргээх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.4, 13.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам”-ын 9.2, 9.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монгол тэрбумтан” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээсугай.
2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд сэргээсэн талаарх тэмдэглэгээг 2012 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор хийлгэхийг “Монгол тэрбумтан” ХЗХ /Г.Хосбаяр/-нд үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах болон олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.



ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

001482